



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 20 өдөр

Дугаар 1/83

Мандалговь

Халдваргүйжүүлэлтийн үйл ажиллагааг
зохион байгуулах тухай

“Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6.6 дахь заалт, 30 дугаар зүйлийн 30.1.6, “Гамшгаас хамгаалах тухай” хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.4, 32.1.8, “Эрүүл мэндийн тухай” хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. “Коронавируст халдвар (COVID-19)-ын үед орон нутгийн шалган нэвтрүүлэх хяналтын цэгээр нэвтрэх тээврийн хэрэгсэлд халдваргүйжүүлэлт хийх түр журам”-ыг хавсралтаар батласугай.

Хоёр. Түр журмыг хэрэгжүүлж ажиллахыг “Наранбулаг” ахуйн шавьж, мэрэгч устгал, халдваргүйжүүлэлтийн газар (М.Алтанцог)-т үүрэг болгосугай.

Гурав. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа бүх аж ахуйн нэгж, байгууллагууд, орон сууцны орц, хонгил, айл өрх, албан байгууллагын бие засах газар, бохир усны цооногт цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт хийлгэхийг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

Дөрөв. Энэхүү захирамж, журмын хэрэгжилтийг хангуулж, мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллахыг Эрүүл мэндийн газар (Г.Бат-Орших), Онцгой байдлын газар (М.Адьяабаатар), хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), Цагдаагийн газар (О.Амарсанаа) нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

482010255

Аймгийн Засаг даргын 2020 оны
03 дугаар сарын 20-ны өдрийн 178 дугаар
захирамжийн хавсралт

**"КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (COVID-19) -ЫН ҮЕД ОРОН НУТГИЙН
ШАЛГАН НЭВТРҮҮЛЭХ ХЯНАЛТЫН ЦЭГЭЭР НЭВТРЭХ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛД
ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭЛТ ХИЙХ ТҮР ЖУРАМ"**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү түр журмын зорилго нь шинэ коронавируст халдварын үед орон нутгийн шалган нэвтрүүлэх хяналтын цэгээр нэвтрэх тээврийн хэрэгсэлд халдваргүйжүүлэлт хийхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2. Халдваргүйжүүлэлтийн үйл ажиллагаанд энэхүү түр журам болон Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Эрүүл мэндийн яам, бусад мэргэжлийн байгууллагаас гаргасан зөвлөмж, журам, зааврыг мөрдөнө.

Хоёр. Халдваргүйжүүлэлт хийх үйл ажиллагаа

2.1. Халдвар бүртгэгдсэн газрын шалган нэвтрүүлэх хяналтын цэгээр гарах, орох чиглэлийн тээврийн хэрэгсэл бүрт халдваргүйжүүлэлт хийнэ.

2.2. Халдвар бүртгэгдээгүй газрын шалган нэвтрүүлэх хяналтын цэгээр орох чиглэлд нэвтрэх тээврийн хэрэгсэлд урьдчилан сэргийлэх халдваргүйжүүлэлт хийнэ.

2.3. Тээврийн хэрэгсэлд хийх халдваргүйжүүлэлтийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.12.8 дахь заалтад заасны дагуу халдваргүйжүүлэх үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллага хийж гүйцэтгэнэ.

2.4. Монгол улсын бүртгэлд бүртгэгдсэн, хэрэглэх ашиглах заавар нь баталгаажсан, хэрэглэх хугацаа хүчинтэй, сав, баглаа боодлын бүрэн бүтэн байдал алдагдаагүй, хаяг шошго тодорхой бодисыг халдваргүйжүүлэлтэд ашиглана.

Гурав. Халдваргүйжүүлэлт хийх аж ахуйн нэгж, байгууллагын үүрэг

3.1. Тээврийн хэрэгсэлд халдваргүйжүүлэлт хийхдээ Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн ерөнхий захирлын 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/15 дугаар тушаалаар баталсан "Коронавируст халдварын үед халдваргүйжүүлэлт хийх түр заавар", Халдварт өвчин судлалын үндэсний төвийн ерөнхий захирлын баталсан "Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх халдваргүйжүүлэлт хийх зааварчилгаа" зэрэг тусгасан халдваргүйтгэлийн бодисыг ашиглан, аргачлалын дагуу хийнэ.

3.2. Тээврийн хэрэгсэлд халдваргүйжүүлэлт хийх ажилтныг хувийн хамгаалах хувцас, хэрэгсэл, халдваргүйтгэлд зайлшгүй шаардлагатай багаж хэрэгслээр бүрэн хангаж, аюулгүй ажиллагааны зааварчилгааг өгсөн байна.

3.3. Тээврийн хэрэгсэлд халдваргүйжүүлэлт хийсэн тухай баримтыг 2 хувь үйлдэж, жолоочид нэг хувийг өгнө.

3.4. Халдваргүйжүүлэлт хийж буй аж ахуйн нэгж, байгууллага нь халдваргүйтгэлийн бодисын чанар, хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг бүрэн хариуцна.

Дөрөв. Тээврийн хэрэгслийн жолоочийн үүрэг

Тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх цэгийн заасан газарт зогсоож, халдваргүйжүүлэлтийг хийлгэнэ.

4.1. Шалган нэвтрүүлэх цэгт ажиллаж байгаа холбогдох байгууллагын ажилтнуудын тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлж, халдваргүйжүүлэлтийн

ажилтны зөвлөмж, зааврыг мөрдөнө.

4.2. Халдваргүйжүүлэлт хийлгэсэн тухай баримтын нэг хувийг авч, шаардлагатай тохиолдолд дараагийн шалган нэвтрүүлэх цэгт шалгуулна.

4.3. Тээврийн хэрэгслийн гадна, дотор талыг тогтмол цэвэрлэн, хог хаягдлыг уут саванд хийж, суурин газрын хогийн цэгт хаяна.

4.4. Тээврийн хэрэгсэлд халдваргүйжүүлэлт хийсэн тухай баримтыг хуурамчаар үйлдэх, дахин ашиглахыг хориглоно.

Тав. Бусад

5.1. Халдваргүйжүүлэлт хийлгээгүй тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх цэгээр нэвтрүүлэхийг хориглоно.

5.2. Энэхүү түр журмыг зөрчсөн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.